

Халхын голын байлдааны ялалт нь ах дүү социалист аль ч оронд хар санаат хэн нэгэн гурав дахь этгээд түрэмгийлэн халдвал тэдний хамтын хүчнээс ямар хариу авч болохыг яруу тод илтгэн харуулсан Халхын голын байлдааны ялалтын түүхэн сургамж өнөө ч чухал ач холбогдолтой хэвээр байна. Халхын голын байлдааны ялалтын түүхэн сургамжийг дэлхийн олон улс орон бахархан тэмдэглэхдээ дэлхийн II дайны урьдал байсан гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

**СУНЬ ЯТСЕН БА Монгол
(1911-1924 ОН)
Ц. Батбаяр**

Хятадын ард түмний үнэнч хүү, цогт ардчилсан хувьсгалч Сунь Ятсен (1866—1925) ялалт бахархал ялагдал гашуудал хосолсон зөрчил тэмцлээр дүүрэн амьдралын замыг туулсан юм. Түүнийг бид 1911 оны цагаагчин гахай жилийн хувьсгалын (Синьхайн) эцэг, Хятадын анхны бүгд найрамдах улсын түр ерөнхийлөгч, «ардын гурван зарчмыг» зарлан тунхаглагч гэсэн талаас нь илүү мэддэг билээ. Харин тэрээр хэдэн зуун жилийн гүн нойроос сэрсэн Азийн ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцэл, түүн дотор Монголын ард түмний тэмцэлд хэрхэн хандаж байсан нь төдийлөн тодорхойгүй.

Тухайн үедээ В. И. Ленин Сунь Ятсений үзэл бодлын үндсэн агуулгыг задлан шинжлээд, түүний үзэл санааг «дайчин ардчилал»-ын шинжтэй гэж тодорхойлжээ. Сунь Ятсеныг «ариун санаа ба баатарлаг чанараар» нэвтэрхий ардчилсан хувьсгалч гэж нэрлэхийн хамт В. И. Ленин түүний үзэл бодлын сөрөг талыг ил тод харж байв. Тухайлбал 1912 онд бичсэн өгүүлэлдээ тэрээр Сунь Ятсений «жигжиг хөрөнгөтний үл гүйцэлдэх», тэр ч байтугай зарим харгис үзэл бодлыг түүний үзэл санааны «хувьсгалт ардчилсан гол хэсгээс» тусад нь салган шүүмжлэхийн чухлыг тэмдэглэж байжээ.¹ Синьхайн хувьсгалын дараа хятад биш үндэстний талаар баримталж байсан Сунь Ятсений үзэл бодолд мөн ийм байр сууринаас хандах нь оновчтой.

Цагаагчин гахай жилийн хувьсгал, түүнтэй холбогдон хуучин манж Чин улсын зах хязгаар нутаг, ялангуяа Монголын байдал Сунь Ятсений анхаарлыг татаж ямар нэг хэмжээгээр түүний сэтгэлийг түгшээж байв. 1912 оны нэгдүгээр сард Бээжинд хүрэлцэн ирсэн монгол ноёдод илгээсэн илгээлтдээ тэрээр “Монголын байдал туйлын түгшүүртэй» байгааг анхааруулж байсан нь санамсаргүй зүйл биш юм.² Сунь Ятсен зах хязгаар нутагт өдрөөс өдөрт өрнөж байгаа салан тусгаарлах хөдөлгөөнийг өөрийн нүдээр ажиглан харж байв. Шударга ёсны төлөө Ухань хот анхлан боссоны дараа арав гаруй муж газар дараа дараалан тусгаар тогтнолоо зарлаж, манж Чин улсын засаг

захиргааг хүлээн зөвшөөрөхөө больсныг Сунь Ятсен тэмдэглээд «Монгол болон Төвд ч мөн адил хүсэл эрмэлзэлтэй» гэдгийг хүлээн зөвшөөрч байв.³

Гэвч тэрээр хан үндэстнээс бусад манж Чин улсын харьяанд байсан ард түмний өөрөө өөртөө засан тохиох эрх, түр алдагдсан төр улсаа сэргээн тогтоох эрмэлзлийг тухайн үедээ огт үгүйсгэж байсан нь маргаангүй юм. Иймэрхүү шаардлага тавьсан хятад биш ард түмний ямарваа нэг хөдөлгөөнийг Сунь Ятсен «гаднын хүчний хатгалгаар хийгдсэн гаж буруу үйл хөдлөл» буюу «Хятадыг хагалан бутаргах гэсэн самуун этгээдийн оролдлого» гэж тодорхойлж байв. Энэ нь түүний 1912 онд Бээжинд болсон Монгол-Төвдийн нэгдсэн хорооны хуралдаан дээр хэлсэн үгэнд тод тусгалаа олсон байдаг.⁴

Манжийн төрийг түлхэн унагаасны дараа манж Чин улсын хуучин газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хэвээр хадгалах, түүнд харьяалагдаж байсан олон үндэстэн ястныг нэгэн дээвэр дор нэгтгэн зангидах явдлыг Сунь Ятсен эн тэргүүнд тавьж байв. 1912 оны нэгдүгээр сард Хятадын бүгд найрамдах улсын түр ерөнхийлөгчийн албан тушаалд дэвшин орох үед нийтлүүлсэн тунхаглалдаа: «Төр улсын үндэс суурь нь ард түмэндээ тулгуурладаг. Хан, Манж, Монгол, мусульман ба төвдүүдийн нутаг дэвсгэрийг нэгэн улсад нэгтгэхийн хамт, хан, манж, монгол, мусульман ба төвд нарыг нэгэн гэр бүлд нэгтгэн зангидсан тэр цагт л сая бид үндэсний нэгдлийг хангана» гэж албан ёсоор мэдэгдэж байв.⁵ Иймээс ч тэрээр Синьхайн хувьсгалын үр дүнд байгуулагдсан бүгд найрамдах улсыг «таван үндэстний бүгд найрамдах улс» гэж нэрлэж байв.

Сунь Ятсен гаднын хүчний нөлөөг хэтэрхий өндөрт өргөн, хятад биш үндэстний үндэс угсаагаа гэсэн дотоодын хүчний тэмүүллийг үл ойшоож байсан нь илэрхий. Тиймээс ч тэрээр манж, монгол, мусульман, төвд нарыг империалист гүрний тавьсан «торонд» орсон бөгөөд харин тэднийг энэ «торноос» яаж мулталж авах тухай бодолхийлэх хэрэгтэй гэж байв. Тэднийг тэтгэн хамгаалж чадах хүч бол гагцхүү хан үндэстэн гэж Сунь Ятсен тооцож байлаа. 1920-иод оны эхээр хэлсэн нэгэн үгэндээ тэрээр «Манжууд Япон, монголчууд Оросын нөлөөний хүрээнд байгаагаас гадна Төвд Английн өмч хөрөнгө нь бараг болохдоо тулаад байна. Үүнээс үзвэл тэд өөрсдийгөө хамгаалах чадалгүй бөгөөд бид ханчууд л тэдэнд туслах ёстой» гэж мэдэгдэж байжээ.⁶

Үүнтэй нэгэн зэрэг Сунь Ятсен Хятад биш үндэстнийг цэргийн хүчээр дарангуйлан номхотгох гэсэн аливаа оролдлогыг жигшин буруушааж байсныг хэлэх хэрэгтэй. 1924 онд хэлсэн нэгэн үгэндээ тэрээр зарчимч байр суурь баримтлах нь цэрэг зэвсэг хэрэглэхээс илүү хүчтэйг цохон тэмдэглээд тухайн үед Бээжингийн засгийн газар Сюй Шужэнийг илгээн Монголыг номхотгон дарахыг оролдож байсныг илчлэн шүүмжилж байв.⁷

1919 оны 10 дугаар сарын 10-нд Шанхайд урьдын Хятадын хувьсгалт намыг Хятадын үндэсний нам (Жунго-гоминьдан буюу товчилбол гоминьдан) болгон өөрчлөн зохион байгуулав. Гоминьдан намын зорилгыг Хятадад бүгд найрамдах засгийг бэхжүүлэх, Сунь Ятсений «ардын гурван зарчмыг» амьдралд хэрэгжүүлэх гэж тодорхойлжээ. Өөрийн улс төр, эдийн засгийн үзэл бодлыг сурталчлахын тулд Сунь Ятсен «Бүтээн байгуулалт» (Зяньшэ) сэтгүүлийг үндэслэн 1919 оны 8

дугаар сараас Шанхайд хэвлэн гаргаж эхлэв. Мөн Гоминьдан намын нөлөөтэй гишүүдийн нэг Дай Зытао Шанхайд «Ням гаригийн ярилцлага (синьци пинлунь) долоо хоног тутмын сонин эрхэлж байснаас гадна 1919 оны 8 дугаар сараас Гуанжоуд англи хэл дээр «Алс Дорнодын улс төрийн ухааны тойм» (Фар истерн политикл сайенс ревью) сэтгүүлийг Сунь Ятсений талынхан хэвлэх болов.

Үүнтэй холбогдуулан гадаад ертөнц, ялангуяа Хятадын хөрш зэргэлдээ орнуудын тухай мэдээллийг Сунь Ятсен ямар эх булагаас ихэвчлэн олж мэдэж байв гэсэн асуулт гарч байна. Сунь Ятсенийг судлаач америкийн эрдэмтэн Мартин Уилбурын бичсэнээр Шанхайд байх хугацаандаа Сунь Ятсен англи хэл дээр гардаг сонин хэвлэлийг бараг алгасахгүй үздэг байжээ. Тэрээр гаднын зочидтой уулзах сонин сурвалжлагч нарт ярилцлага өгөхийг тээртэй зүйл гэж тооцдоггүй байв. Ялангуяа өрнөдийн орнууд болон Японд боловсрол олсон Хятад хүмүүсийг Сунь Ятсен үйл ажиллагаандаа өргөн татан оролцуулах бодлого явуулж байжээ. Энэ бүгд нь түүнийг тэр үеийн хувьсгалт хөдөлгөөний удирдагчдын дотроос Хятадын гадаад ертөнцийн талаар харьцангуй өргөн мэдлэгтэй хүн байжээ гэсэн дүгнэлтэнд Уилбурыг хүргэжээ.⁸

1920 оны үеэс эхлэн умард зүгийн их хөрш Зөвлөлт Оросын тухай мэдээллийг дам биш шууд хүлээж авах боломж нээгдсэн байна. Үүнд 1921 онд Гуанжоуд Зөвлөлт Оросын мэдээллийн агентлаг РОСТ-ын салбар нээгдсэн явдал чухал зүйл байв. Энэ салбар орон нутгийн хэвлэлийг Зөвлөлт Оросын байдлын тухай үнэн бодит мэдээллээр хангахад туйлын чухал үүрэг гүйцэтгэжээ. 1920 оны намар Шанхайд Сунь Ятсен Коминтерний төлөөлөгч Зөвлөлтийн коммунист Г. Н. Войтинскийтэй уулзаж Октябрийн хувьсгал, Зөвлөлт Оросын амьдралын тухай сонирхож асуусан байна. Мөн тэр үеэс эхлэн Зөвлөлт Оросын гадаад хэрэг эрхэлсэн ардын комиссар Г.В. Чичерин ба Сунь Ятсений хооронд харилцаа тогтож, захидал цахилгаан тогтмол солилцох болжээ.

1922 оны хавар Хятадын залуучуудын социалист эвлэлийн хуралд оролцохоор Гуанжоуд ирсэн КИМ-ын төлөөлөгч С. А. Далин, Сунь Ятсентай хэд хэдэн удаа уулзаж тодорхой ярилцсан байна. Нэгэн удаагийн уулзалт дээр Монголд хийсний нэгэн адил тийм эргэлтийг Зөвлөлт Орос Манжуурт хийх боломж байна уу гэж Сунь Ятсен асуусан тухай С. А. Далин дурсан бичсэн байдаг. С. А. Далины бичсэнээс үзвэл тэр үеийн Монголд болж байгаа үйл явдлын тухай Сунь Ятсен дан ганц англи хэл дээрх сонин хэвлэлээс олж мэддэг байсан нь эргэлзээгүй. Иймд Далин Монгол дахь үйл явдлын тухай Сунь Ятсенд тодорхой ярьж, Монголын ард түмний байгуулсан хувьсгалт Монголын засаг төр нь үзэл санааны хувьд Хятадын хувьсгалт хүчинтэй ижил төрөл болохыг тайлбарласан байна.⁹

1922 оны 8 дугаар сарын 22-нд Бээжингийн засгийн газартай хэлэлцээ хийхээр Зөвлөлт Оросын онц бөгөөд бүрэн эрхэт төлөөлөгч А. А. Иоффе Бээжинд хүрэлцэн иржээ. Хоёр орны хооронд албан ёсны дипломат харилцаа тогтоох, энэ үндсэн дээр харилцан сонирхсон чухал чухал асуудлыг хэлэлцэн шийдэх явдал Иоффегийн гол зорилго байв. Бээжингийн засгийн газар хэдийгээр хэлэлцээ хийхээс татгалзаагүй боловч, элдэв шалтаг заан хэлэлцээ эхлэх явдлыг саатуулж байв. Зөвлөлт-Хятадын хэлэлцээ эхлэх урьдчилсан нөхцөлийн

нэг нь Монголоос Зөвлөлтийн цэргийг гаргах явдал гэж Бээжингийн ГЯЯ мэдэгдэж байлаа. Ийм нөхцөлд Өмнөд Хятадын засгийн газар, түүний удирдагч Сунь Ятсен ямар байр суурь баримталж байв?

Бээжинд ирсэн даруйдаа А. А. Иоффе Сунь Ятсентай харилцаа тогтоож, 1922 оны 8 дугаар сараас 12 дугаар сарын хооронд дөрвөн захиа илгээж, хариу гурван захиа хүлээн авчээ. А. А. Иоффе Бээжингийн засгийн газартай хийж байгаа хэлэлцээ, түүнд учирч буй бэрхшээлийн тухай мэдээлж байсан бол Сунь Ятсен Хятадын дотоод улс төрийн байдал, өөрийн цэрэг-улс төрийн төлөвлөгөөг танилцуулж, империалист гүрнүүдийн ашиг сонирхолд хөтлөгдсөн Бээжингийн засгийн газрын байр суурийг эрс шүүмжилж байв. 1922 оны 12 дугаар сард Сунь Ятсен өөрийн бие төлөөлөгч Чжан Цзиг Бээжин илгээж А. А. Иоффетэй Шанхайд уулзан ярилцахаар хэлэлцэн тохирчээ. А. А. Иоффе Япон явах замдаа Шанхайд буудаллаж, Сунь Ятсентэй хэд хэдэн удаа уулзаж ярилцсан байна. Уулзалтын дүнд хоёр тал 1923 оны 1 дүгээр сарын 26-нд хамтарсан мэдэгдэл боловсруулж, хэвлэлд нийтлүүлсэн билээ. Мэдэгдэл нь зөвлөлт-Хятадын харилцааны иж бүрэн асуудлаар хоёр талын үзэл бодол нэгдмэл болохыг илтгэн харуулсан юм. Бээжингийн засгийн газраас дэвэргэн хөөрөгдөж байсан «Монголын асуудал» гэгчийн талаар Сунь Ятсен: «ялангуяа оросын цэрэг Монголоос гарсны дараа Бээжингийн засгийн газар Оросын эсрэг чиглэсэн цагаан гвардийнхны өдөөн хатгах дайсагнасан ажиллагаа дахин сэргэх явдлыг зогсоох боломжгүй байгаа одоо үед тийнхүү оросын цэргийг нэн даруй гаргахын онц чухлыг ч гэсэн, тэр нь Хятадын үнэнхүү эрх ашигт нийцэж байгааг ч гэсэн би олж харахгүй байна» гэж мэдэгдэж байлаа.¹⁰

Зөвлөлт-Хятадын хэлэлцээ 1923 оны 9 дүгээр сард Бээжинд ЗХУ-ын Онц бөгөөд бүрэн эрхт төлөөлөгч Л. М. Карахан хүрэлцэн ирснээр төгсгөлийн шийдвэрлэх шатандаа орсон юм. Оросын ажилчин-тариачны засгийн газрыг нэн даруй үг дуугүй хүлээн зөвшөөрөхийг хятадын олон түмний өргөн давхарга шаардаж байсан энэ үед Гоминьдан нам, түүний удирдагч Сунь Ятсений байр сууриас олон зүйл шалтгаалж байв. Дорнодахины бага буурай орны талаарх Зөвлөлт Оросын гадаад бодлогыг гүтгэн гүжирдэх гэсэн харгис хүчний дуу хоолойг Сунь Ятсен илчлэн няцааж байлаа. Үүнтэй холбогдуулан Сунь Ятсений нэгэн мэдэгдлийг иш татахад илүүдэхгүй. Тэрээр: «БНМАУ-д Оросын нөлөө их байна гэж тооцдог. Тэнд Оросын нөлөө их байгаа нь харин ч сайн юм биш үү. Монгол нь тухайн үедээ Хятадын империалистуудаас, дараа нь Унгерн болон тэдний хамсаатнаас хичнээн их хэлмэгдсэнийг бид мэднэ. Тиймээс тэр нь эрх чөлөөт орон байг л даа» гэж мэдэгдэж байжээ.¹¹

Зөвлөлт-Хятадын хэлэлцээ шувтаргын шатандаа орж, Зөвлөлт Оросыг хүлээн зөвшөөрөх хөдөлгөөн Хятад орон даяар өрнөж байсан нь Монголын төлөөлөгчдийг Хятадад очиж, хятадын хувьсгалт хүчнийхэн, түүний дотор Гоминьдан намтай шууд хэлхээ холбоо тогтоох таатай нөхцөл бүрдүүлсэн ажээ. Үүнд 1923 оны 11 дүгээр сард тэр үед Монгол Ардын Намын Төв Хорооны дарга байсан япон хэмээх Б. Данзан нарын төлөөлөгчид Нийслэл Хүрэнээс Бээжинг чиглэн мордсон байна. Уг айлчлалын зорилгыг «Харьяат хорооноос Дундад иргэн улсад очиж тус улсын үнэн байдлыг нэвтрүүлэн, мөн Дундад улсын үнэн байдлыг мэдэхээр явуулсан» гэж тодорхойлжээ.¹²

Б. Данзан нар Бээжин, Шанхайгаар дайран 1924 оны нэгдүгээр сард Гуанжоуд хүрэлцэн очсон байна. Данзанг Гуанжоуд очих үед Гоминьдан намыг өөрчлөн зохион байгуулах анхдугаар их хурал хийж байгаатай таарчээ. Манай намын төлөөлөгчид гоминьдан намын их хуралд оролцсон эсэх нь тодорхойгүй боловч тэднийг Сунь Ятсен хүлээн авч уулзсан нь маргаангүй юм. Үүнийг Сунь Ятсений түүвэр зохиолд байгаа баримтууд нотолж байна. Тэр ч байтугай Б.Данзан Сунь Ятсентэй хэд хэдэн удаа учирч ярилцсан гэж тэр үед гарч байсан «Ардын эрх» сонин бичжээ.¹³

Манай намын төлөөлөгчидтэй Сунь Ятсений ярилцсан ярианы тэмдэглэл бүрэн эрхээр үлдэж хоцроогүй боловч ерөнхий агуулга нь мэдэгдэж байна. Монголын төлөөлөгчдийг бусад төлөөлөгчдийн хамт 1924 оны 1 дүгээр сарын 20-нд хүлээн аваад хэлсэн үгэндээ Сунь Ятсен «Гадаад Монгол нь дундад иргэн улсын үеэс Хятадаас салан тусгаарлаж, дотоод засаг нь их л боловсронгуй болж, мөн их хэмжээний цэрэг зассан бөгөөд иймээс тэд өнөөдөр бүр нэгэн тусгаар тогтносон улс болжээ» хэмээн хүлээн зөвшөөрөөд Бээжингийн засгийн газраас ялгаатай нь манай өмнөд засгийн газар цэргийн хүч хэрэглэн Монголд халдан довтлох санаа огтхон ч үгүй хэмээн мэдэгджээ. Үүнтэй нэгэн зэрэг тэрээр ирээдүйд Монгол Хятадтай дахин холбоо тогтоож нэгэн Их Хятад Иргэн улсыг (Чжунхуа миньго) байгуулах болов уу гэсэн хүслээ илэрхийлжээ.¹⁴

Түүний энэхүү мэдэгдэл нь 1924 оны 1 дүгээр сард хийгдсэн Гоминьданы анхдугаар их хурлын тунхаглалын үзэл санааг удирдлага болгосон нь илэрхий. Энэ нь юуны өмнө Хятад биш ард түмний өөртөө засах тохинох эрхийг хүлээн зөвшөөрсөн явдал юм. Тунхаглалд энэ тухай: «Хятадын нутаг дэвсгэр дэх бүх үндэстний өөртөө засан тохинох эрхийг хүлээн зөвшөөрч байгаагаа Гоминьдан нэр төртэй мэдэгдэж байна» гэж тунхаглажээ. Тунхаглалд мөн «Империализм ба милитаризмын эсрэг хувьсгалын ялалтын дараа эрх чөлөөтэй бөгөөд нэгдмэл Хятадын бүгд найрамдах улсыг байгуулахын чухлыг онцлон заасан байдаг.¹⁵ Үүнээс үзвэл Сунь Ятсен Хятадын төрийн байгууллыг ирээдүйд холбооны улсын хэлбэрээр зохион байгуулах үзэл бодлыг илэрхийлсэн нь илт байна.

1924 оны 1 дүгээр сараас 8 дугаар сарын турш уншсан «ардын гурван зарчмын» тухай лекцүүддээ Сунь Ятсен жижиг буурай үндэстнийг дэмжих тухай үзэл бодлоо удаа дараа илэрхийлж байв. Тухайлбал, 1924 оны 2 дугаар сарын 3-нд уншсан «национализмын» талаарх хоёрдугаар лекцдээ Сунь Ятсен: «Саяхан Гуанжоуд болсон Гоминьданы анхдугаар их хуралд Монголын төлөөлөгчид манай засгийн газар урьдын империалист гадаад бодлогыг явуулсан хэвээр байна уу гэдгийг мэдэхээр иржээ» гэж танилцуулаад гоминьданы улс төрийн программд ямар ч империалист өнгө аяс үгүй бөгөөд бага буурай улс үндэстнийг тэтгэн дэмжих учиртай бөгөөд харин эцэстээ нэгдсэн нэгэн их дорно дахины улсыг (Дунфаньды даго) байгуулах зорилготой болохыг ухуулсан байна.¹⁶

Гоминьданы их хурлын материал, Сунь Ятсений лекцүүд түүнээс хятад биш үндэстэнд хандах хандлагад тодорхой өөрчлөлт гарсныг харуулж байна. Үүний шалтгааныг амьдралынхаа сүүлийн жилүүдэд Сунь Ятсен Зөвлөлтийн туршлага, түүн дотор үндэстний бүтээн байгууллын туршлагыг анхаарах болсон, мөн Гоминьдан нам Хятадын

коммунист намтай хамтран ажиллах замд шилжсэн, түүнчлэн Коминтерний санал зөвлөгөө түүнд нөлөөлж байснаар тайлбарлаж болох юм. Үүний хамт Сунь Ятсений үзэл бодолд ажиглагдах болсон шинэ зүйлийг түүний урьдын үзэл бодолд «эргэлт» гарсан биш, харин шинэ нөхцөл, шинэ шаардлагад тохируулан «зохицох» гэсэн оролдлого гэж үзвэл бодитой болно.

Монголын талаарх Сунь Ятсений байр сууринд гарсан өөрчлөлтийг ч гэсэн энэ үүднээс авч үзэх нь оновчтой. Тэрээр 1910-аад оны эхээр Монголын Хятадаас салан тусгаарлаж, тусгаар тогтнох эрхийг бүрмөсөн үгүйсгэж байсан бол 1920-иод оны эхээр ийм эрхийг хүлээн зөвшөөрөх болсон байна. Монголд ардын хувьсгал ялж, Монголын ард түмэн бие даан оршин тогтнох чадвараа бүрэн харуулсныг Сунь Ятсен зөвшөөрөхөөс өөр аргагүй байдалд хүрсэн юм. Үүнд түүнээс Зөвлөлт Оростой тогтоосон нягт холбоо, ХКН-ын эрүүл саруул хүчинтэй хамтран ажилласан явдал нөлөөлсөн нь гарцаагүй. Гэвч Сунь Ятсен амьдралынхаа эцэс хүртэл өөрийн үзэл бодлын зөрчилтэй тал, түүн дотор бусад үндэстний талаарх «их гүрний» үзэл бодлоос бүрмөсөн ангижирч чадаагүй юм. Энэ нь түүний дорно дахины нэгдмэл нэгэн их улсын тухай мөрөөдөлд тусгалаа олжээ.

1924 онд манай намын төлөөлөгчидтэй уулзахдаа Сунь Ятсен хэлэхдээ: «...бидний хоёр улс өмнө, умраас хөгжин мандаж дундад бүхий харгисуудыг устгаж, ард түмнийг гадаад дотоодын харгисуудын эзэрхэг мэдлээс ангижруулж чадах гэж итгэмүй. Үүнд, хэн хэний үйл бүрэн бүтнээр бүтэж, тус тусын ард түмэн эрх чөлөөгөө олж, үүрд энх түвшнээр аж төрж тус тус тогтнох болтугай»¹⁷ гэсэн өөдрөг үгэнд түүний хувьсгалч ардчилсан үзэл бодол тод томруун туссан нь эргэлзээгүй.

1. В. И. Ленин, Зохиолууд боть 18, УБ 1965, 162 дахь тал
2. Гофу цюаньшу (Сунь Ятсений зохиолын, бүрэн түүвэр), Тайбэй, 1970, 457 дахь талд байгааг В. А. Богословский, А. А. Москалев Национальный вопрос в Китае (1911—1949), М, 1984, с. 21-ээс иш татав.
3. Сунь Ятсен. Избранные произведения, издание второе м, 1985 с. 121.
4. В. А. Богословский, А, А, Москалев Национальный вопрос в Китае (1911— 1949), М., 1984, с. 22
5. Сунь Ятсен Избранные произведения, М., 1985, с. 121.
6. Гофу цюаньшу, Тайбэй, 1970, 889 дэх талд байгааг В. А. Богословский, А. А. Москалев Национальный вопрос в Китае (1911—1949) М., 1984, с, 22-аас иш татав,
7. Сунь Жуншань сюаньцзи (Сунь Ятсений түүвэр зохиол) Бээжин, 1957. , боть 2. 518—519 дэх тал.
8. Sun Yat-sen: Frustrated patriot by с, Martin Wilbur, Columbia University Press, New York, 1976, р. 16—77
9. С. А. Далин, Китайские мемуары, 1921—1927. м, 1982, с. 136
10. Советско-Китайские отношения. 1917—1957, Сборник документов. М., 1959, с. 65
11. П. Старицина, К вопросу о советско-монгольских отношениях, «Труды Московского института востоковедения» сб. 5, М., 1947 с. 292
12. «Ардын эрх» сонин, 1924, IV. 31. № 6
13. Мөн тэнд
14. Сунь Жуншань сюаньцзи (Сунь Ятсений түүвэр зохиол) Бээжин, 1957., боть 2, 518—519 дэх тал